

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

а. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

б. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Доор өгүүлсэн эртний урлагийн дурсгалуудаас аль нь Мезолит (Дунд чулуун зэвсгийн үе)-ын үед хамаарах вэ? (2 оноо)
А. Ховд аймгийн Буянт сумын нутаг дахь Чандмань хар үзүүрийн зураг
В. Ховд аймгийн Манхан сумын нутаг дахь Ишгэн толгойн хадны зураг
С. Увс аймгийн Сагил сумын нутаг дахь Хар үзүүрийн хадны зураг
D. Увс аймгийн Сагил сумын нутаг дахь Могоогийн хадны зураг
E. Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны зураг
2. Монгол нутаг дахь эртний хүмүүс байгаль дахь бүтээгдэхүүнийг түүвэрлэх буюу бэлнээр нь авч хэрэглэж байснаа яваандаа өөрсөддөө зориулан үйлдвэрлэх болсон байна. Энэхүү өөрчлөлтийг түүхийн шинжлэх ухаанд хэрхэн нэрийддэг вэ? (2 оноо)
А. Палеолитийн хувьсгал
B. Мезолитийн хувьсгал
C. Неолитийн хувьсгал
D. Энеолитийн хувьсгал
E. Хүрэл зэвсгийн хувьсгал
3. Хуучин чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн эрхлэж байсан аж ахуй аль нь вэ? (1 оноо)
А. Худалдаа ба ан агнуурын аж ахуй
B. Үр үндэс түүх ба ан агнуурын аж ахуй
C. Мал аж ахуй ба ан агнуурын аж ахуй
D. Газар тариалан ба худалдааны аж ахуй
E. Мал аж ахуй ба үр үндэс түүх аж ахуй
4. Монгол нутгаас илэрсэн буган хөшөөний дурсгалын дунд хүндтэй байр эзэлдэг “Дааган дэлийн буган хөшөө” хаана байдаг дурсгал вэ? (1 оноо)
А. Архангай аймгийн Эрдэнэмандал сум
B. Ховд аймгийн Мөст сум
C. Завхан аймгийн Шилүүстэй сум
D. Хөвсгөл аймгийн Мөрөн сум
E. Увс аймгийн Түргэн сум
5. Хүрэл зэвсгийн үеийн хадны сийлмэл зургийн дурсгалд аль нь багтах вэ? (1 оноо)
А. Ховд аймаг Манхан сум Хойт сэнхэрийн агуйн зураг
B. Улаанбаатар хотын ойр Их тэнгэрийн амны хадны зураг
C. Увс аймгийн Сагил сумын Могоогийн хадны зураг
D. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн амны хадны зураг
E. Ховд аймаг Манхан сумын Ишгэн толгойн хадны зураг
6. НТӨ 1250 он хэддүгээр зуун бэ? (1 оноо)
А. НТӨ X зуун
B. НТӨ XI зуун
C. НТӨ XII зуун
D. НТӨ XIII зуун
E. НТӨ XIV зуун
7. Хүннү нарын хэрэглэж байсан, бугын дүрс бүхий зээгт наамалтай эсгий ширдэг хаанаас илэрсэн бэ? (2 оноо)
А. Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан усны хавцал
B. Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой
C. Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Ноён уул
D. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Луут
E. ОХУ-ын Буриадын нутаг Иволгийн суурин
8. Европт нүүн очсон Хүннү нар НТ 445 онд хэн гэдэг хааны үед хүчирхэгжин Дон мөрнөөс Дунай мөрөн хүртэлх газар нутгийг эзлэн, Зүүн Ромын эзэнт улстай хил залгах болсон бэ? (1 оноо)
А. Түмэн
B. Модун
C. Жи Жи
D. Атилл
E. Мого

9. Сяньби улсыг мөхсөний дараа хүчирхэгжин, төр улсаа байгуулсан Жужан нарын нэр хэдий үеэс түүхэнд тэмдэглэгдэж эхэлсэн бэ? (1 оноо)
A. I зуунаас
C. III зуунаас
D. IV зуунаас
B. II зуунаас
E. V зуунаас
10. Сяньби нартай гарал угсаа нэг Тоба нар одоогийн Өвөр монгол, зүүн хойд Хятадыг хамарсан нутагт өөрийн улсыг байгуулсан бөгөөд энэ улс Хятадын түүхэнд ямар нэрээр үлдсэн бэ? (1 оноо)
A. Сүн улс
C. Вэй улс
D. Ляо улс
B. Тан улс
E. Сүй улс
11. Дараах урлагийн дурсгалаас алийг нь Жужан (Нирун) улсын үед холбогдуулан үздэг вэ? (1 оноо)
A. Ховд аймгийн Манхан сум Ишгэн толгойн хадны зураг
B. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Цамбагаравын хадны зураг
C. Ховд аймгийн Үенч сум Ямаан усны хадны зураг
D. Өвөрхангай аймгийн Богд сум Тэвшийн хадны зураг
E. Улаанбаатар хотын ойр орших Их тэнгэрийн амны хадны зураг
12. Түүх шаштирт Жужан (Нирун) улсыг ямар цэрэгтэй байсан хэмээн бичсэн байдаг вэ? (2 оноо)
A. Хатуу нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
B. Даргай нумаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
C. Нум сум, төмөр жадаар зэвсэглэсэн хөнгөн морин цэрэг
D. Хүнд, хөнгөн хоёр төрлийн морин цэрэг
E. Төмөр тэрэгтэй хүнд морин цэрэг
13. Түрэгийн хожуу хаант улсыг үндэслэн байгуулагч, “Элтэрэс” буюу улсыг хураагч хэмээх цолтой хаан аль нь вэ? (1 оноо)
A. Буман
B. Күльтегин
C. Күтүлүг
D. Тоньюкүк
E. Можо
14. Түрэгийн үеийн зарим хүн чулуун хөшөөдийн толгойг тасдсан байдаг бөгөөд толгой нь бүтэн үлдсэн хүн чулуудын нэлээд нь ямар дүрслэлтэй байдаг вэ? (2 оноо)
A. Түрэгжүү төрхтэй унжуу хамартай, том нүдтэй байдаг
B. Уйгур төрхтэй ширвээ сахалтай, онигор нүдтэй байдаг
C. Хятад төрхтэй жижиг шанаатай, онигор нүдтэй байдаг
D. Монголжуу төрхтэй өргөн шанаатай, жартгар нүдтэй байдаг
E. Европжуу төрхтэй өтгөн сахалтай, том нүдтэй байдаг
15. Уйгур улс хэдээс, хэдэн оны хооронд Монгол нутагт төр улсаа байгуулж байсан бэ? (1 оноо)
A. МЭӨ 209-98
B. 98-235
C. 402-555
D. 552-745
E. 745-840
16. Чингис хааны багын анд Жамуха сэцэн аль аймгийн хүн бэ? (1 оноо)
A. Жадран
C. Жалайр
D. Сүлдүсүн
B. Баарин
E. Арлуд
17. Хэрлэн мөрний Хөдөө аралд болсон их хуралдайгаар Чингис хааны гутгаар хөвгүүн Өгөөдэйг Их Монгол улсын хаан ширээнд өргөмжилжээ. Энэ түүхэн үйл явдал хэдэн онд болсон бэ? (1 оноо)
A. 1206 он
B. 1229 он
C. 1235 он
D. 1241 он
E. 1247 он
18. Энэхүү зураг дээр хэдий үеийн түүхэнд холбогдох ямар нэртэй дурсгалыг дүрслэн харуулсан байна вэ? (2 оноо)
A. Их Монгол улсын үеийн Хархорин хотын мөнгөн мод
B. Юань гүрний үеийн Кайпин хотын төв хэсэг
C. Бутралын үед холбогдох Хөх хотын төв цэцэрлэг
D. Бутралын үед холбогдох Цогтын Цагаан хотын төв хэсэг
E. Хятан гүрний үеийн Мүгдэн хотын цэцэрлэгт хүрээлэн



19. “Монголын нууц товчоо”-нд бичсэнээр, “... Тулгуур мэт бие чинь, туйвж одвол, Туг их сүлдий чинь, хэн өргөх юм бэ? Төрсөн дөрвөн хүүгээс чинь, төр барих нь хэн бэ?” хэмээн Чингис хаанд дурдатган сануулсан хүн хэн бэ? (2 оноо)
 A. Өүлэн эх B. Бөртэ хатан C. Хулан хатан D. Есүй хатан E. Есүгэн хатан
20. XIII зууны II хагаст алтан ургийн хоёр хаан нэгэн зэрэг шахам Монголын хаан ширээнд өргөмжлөгдсөн байдаг. Тэдгээр хаад хэн, хэн бэ? (2 оноо)
 A. Гүег, Мөнх B. Мөнх, Аригбөх
 C. Мөнх, Хубилай D. Хубилай, Аригбөх E. Аригбөх, Хүлэгү
21. Хубилай хаан 1260 онд Монголын их хаан ширээнд суусныхаа дараа Хятадын аль хотыг Монгол гүрний нийслэл хэмээн зарлаж Хархорум хотын эсрэг сэргүүлэн тавьсан бэ? (1 оноо)
 A. Иргай B. Нингүт C. Кайпин D. Мүгдэн E. Бянь Лянь
22. Хубилай хаан хэдэн онд Их Монгол улсын нэрийг Их Юань болгон өөрчилсөн бэ? (1 оноо)
 A. 1260 он B. 1264 он C. 1271 он D. 1275 он E. 1281 он
23. Юань гүрний үед уугуул Монгол орон ямар нэртэй байсан бэ? (1 оноо)
 A. Дорныг дайлах муж B. Давааны арын орон
 C. Гадаад их муж D. Давааны өмнөх орон E. Өрнийг дайлах муж
24. Хубилай хааны үед нэр нь үл мэдэгдэх зохиолч бичсэн бөгөөд бидний үед XVI зуунд Ордосын Хутагтай сэцэн хунтайжийн засварласан эх нь уламжлагдан ирсэн гэвэл дараах түүхийн зохиолуудын аль нь вэ? (2 оноо)
 A. “Монголын нууц товчоо” B. “Алтан дэвтэр”
 C. “Юань улсын судар” D. “Цагаан түүх” E. “Зүрхэн толь”
25. Монголын эзэнт улсуудыг нийслэл хоттой нь зөв харгалзуулна уу? (2 оноо)
 1. Их Юань гүрэн а. Самарканд хот
 2. Цагаадайн хаант улс b. Султани хот
 3. Алтан ордны улс c. Сарай хот
 4. Ил хаадын улс d. Кайпин хот
 A. 1- а, 2- b, 3- c, 4- d B. 1- b, 2- а, 3- d, 4- c C. 1- d, 2- а, 3- c, 4- b
 D. 1- d, 2- а, 3- b, 4- c E. 1- c, 2- а, 3- b, 4- d
26. Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын зургаан түмэнд аль нь багтах вэ? (1 оноо)
 A. Хошууд B. Торгууд C. Цахар D. Хойд E. Өөлд
27. Өөрийн харьяалан захирсан нутаг орондоо газар тариалан, гар урлалыг хөгжүүлэн, “Байшин” хэмээх хотыг байгуулж байсан зүтгэлтэн хэн бэ? (1 оноо)
 A. Абтай сайн хан B. Сэцэн хан Шолой
 C. Гүнбилэг мэргэн жинон D. Барсболд жинон E. Алтан хан Ананд
28. Монгол оронд бурхны шашин дэлгэрүүлсэн зүтгэлтнүүдийг газар нутагтай нь тохируулна уу? (2 оноо)
 1. Өмнөд Монгол а. Байбагас баатар, Намхайжамц
 2. Умард Монгол b. Алтан хан, Хутагтай Сэцэн
 3. Баруун Монгол c. Абтай сайн хан, Занабазар
 A. 1-а, 2-б, 3-с B. 1-с, 2-б, 3-а C. 1-б, 2-с, 3-а D. 1-с, 2-а, 3-б E. 1-а, 2-с, 3-б
29. 1936 онд Мүгдэн хотод болсон чуулганаар Өмнөд Монгол Манжид дагаар орсон бөгөөд энэ чуулганд Өмнөд Монголын хэдэн аймгийн, хэдэн ноён оролцсон бэ? (2 оноо)
 A. 16 аймгийн 49 ноён B. 16 аймгийн 51 ноён
 C. 15 аймгийн 49 ноён D. 15 аймгийн 51 ноён E. 14 аймгийн 46 ноён

30. 1638-1639 онд эх нутгаасаа нүүдэллэн явсан дөрвөн Ойрадын Хошууд аймгийн ноён Гүүш хаан хэмээх Төрбайх дараах бүс нутгийн алинд нь суурьшсан бэ? (2 оноо)
- A. Алтайн уул, Енисей мөрөн
 B. Ижил мөрөн, Каспийн тэнгис
 C. Долоон усны газар, Балхаш нуур
 D. Хөх нуур, Түвэдийн газар
 E. Унгарын тал хээр
31. Дараах хууль эрхэмжийн бичгүүдийн аль нь 1640 оны Тарвагатайн чуулганаар батлагдсан бэ? (1 оноо)
- A. Халх Журам
 B. Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг
 C. Шавь яамны улаан хацарт
 D. Хугархай нүүрт хуучин журамлах данс
 E. Дөчин дөрвөн хоёрын Их цааз
32. Халх Монгол Манжид эзлэгдэх түүхэн нөхцлийг бүрдүүлсэн Засагт ханы хямрал хэдэн онд ямар үйл явдлаар эхэлсэн бэ? (2 оноо)
- A. 1640 оны Тарвагатайн чуулганаар
 B. 1655 онд Засагт хан Субадай таалал болсноор
 C. 1661 онд Засагт хан Норов таалал болсноор
 D. 1669 онд Засагт хан Чу мэргэн таалал болсноор
 E. 1686 оны Хүрэн бэлчирийн чуулганаар
33. Түүхэн сурвалжид бичсэнээр, “... Манай чин үнэний тул хишиг хүртээж 49 хошууны ёсоор болгож, миний дотоод, гадаадыг ялгалгүй адил өршөөж үзсэн санааг та ухтугай” хэмээн хэдэн оны ямар чуулган дээр хэн хэлсэн бэ? (2 оноо)
- A. 1639 оны Ширээт цагаан нуурын чуулган дээр Сэцэн хан Шолой хэлсэн
 B. 1640 оны Тарвагатайн чуулган дээр Засагт хан Субадай хэлсэн
 C. 1686 оны Хүрэн бэлчирийн чуулган дээр Түшээт хан Чахундорж хэлсэн
 D. 1689 оны Ар элстэйн чуулган дээр Өндөр гэгээн Занабазар хэлсэн
 E. 1691 оны Долоннуурын чуулган дээр Энх-Амгалан хаан хэлсэн
34. Манжийн эрхшээлийн үеийн Монголын “Хэтэрхий дөрвөн хэргэмтэн” аль нь вэ? (2 оноо)
- A. Ван, бэйл, бэйс, гүн
 B. Ван, тайж, бэйс, гүн
 C. Ван, бэйл, тайж, гүн
 D. Ван, бэйл, бэйс, тайж
 E. Ван, бэйл, бэйс, эфү
35. Манж Чин гүрний эрх баригчдын шууд оролцоотойгоор Халхад нэгэн аймгийг шинээр байгуулан “Сайн ноён аймаг” хэмээн нэрийдсэн байдаг. Энэ аймаг хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)
- A. 1716 он
 B. 1720 он
 C. 1725 он
 D. 1727 он
 E. 1761 он
36. Манж Чин гүрний захиргаанд байх үеийн Ар Монголын аймгуудын нутгийг, одоогийн аймгуудтай ойролцоогоор нь тохируулна уу. (2 оноо)
1. Түшээт хан аймаг
 2. Сэцэн хан аймаг
 3. Засагт хан аймаг
 4. Сайн ноён аймаг
- a. Завхан, Говь-Алтай зэрэг аймаг
 b. Хэнтий, Сүхбаатар зэрэг аймаг
 c. Сэлэнгэ, Төв зэрэг аймаг
 d. Архангай, Өвөрхангай зэрэг аймаг
- A. 1-с, 2-а, 3-б, 4-д
 B. 1-а, 2-с, 3-б, 4-д
 C. 1-с, 2-а, 3-д, 4-б
 D. 1-д, 2-а, 3-б, 4-с
 E. 1-с, 2-б, 3-а, 4-д
37. Манж Чин гүрний эзэн хаан 1901 оноос улс төр, эдийн засаг, соёлын хүрээнд шинэчлэл хийж эхэлсэн бөгөөд энэ нь ямар нэрээр түүхэнд бичигдэн үлдсэн бэ? (1 оноо)
- A. “Шинэ эргэлтийн бодлого”
 B. “Шинэ засгийн бодлого”
 C. “Шинэ төрийн бодлого”
 D. “Шинэчлэн найруулах бодлого”
 E. “Шинэчлэн төлөвлөх бодлого”

38. Жалханз хутагт Дамдинбазар, Хатанбаатар Магсаржав, Манлайбаатар Дамдинсүрэн нарын тэргүүлсэн монгол цэрэг Манж-Хятадын эрх баригчдаас Ховд хотыг чөлөөлсөн үйл явдал хэзээ болсон бэ? (2 оноо)
А. 1911 оны VII сард
В. 1911 оны XI сард
С. 1912 оны I сард
D. 1912 оны VIII сард
E. 1912 оны XI сард
39. Богд хаант Монгол улсын иргэний сургууль 1912 онд аль хотод нээгдэж байсан бэ? (1 оноо)
А. Нийслэл Хүрээ
B. Улиастай
C. Ховд
D. Хаалган
E. Хиагт
40. 1914 онд байгуулсан Улсын доод хуралд ямар албан тушаалтан оролцох эрхтэй байсан бэ? (2 оноо)
А. Олон яамдын тэргүүн, дэд сайдууд
B. Нийслэл хүрээнд байгаа засаг ба засаг бус ноёд
C. Яамдын эрхэлсэн ба дэс түшмэл, эх зохиох түшмэл
D. Ван, бэйл, бэйс, гүн
E. Эрдэнэ шанзудба, да лам нар
41. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монгол улс ямар эрхтэй болсон бэ? (1 оноо)
А. Автономит
B. Сюзарнитет
C. Сувернитет
D. Статус кво
E. Бүрэн тусгаар тогтносон
42. 1919 оны II сард Чита хотод байгуулсан Нармай Монгол улсын засгийн газрын тэргүүнээр дараах зүтгэлтнүүдээс хэнийг нь сонгосон бэ? (2 оноо)
А. Халхын Түшээт хан Дашням
B. Өвөр Монголын Нэйс гэгээн Мэндбаяр
C. Баргын Манлай ван Дамдинсүрэн
D. Буриадын эрдэмтэн Ж.Цэвээн
E. Дөрвөдийн Далай хан Галсаннамжил
43. 1923 оноос аймаг хошуудын хуучин нэрийг халан уул, усны нэрээр нэрлэх болсон байна. Энэ үед хуучны Халхын Засагт хан аймгийг ямар нэрээр нэрлэх болсон бэ? (1 оноо)
А. Хан Хэнтий уулын аймаг
B. Богд хан уулын аймаг
C. Цэцэрлэг мандал уулын аймаг
D. Хантайшир уулын аймаг
E. Чандмань уулын аймаг
44. 1924 онд батлагдсан Монгол улсын анхдугаар үндсэн хуулинд “Жинхэнэ ард”-ын гол зорилго хэмээхийг хэрхэн томъёолсон бэ? (2 оноо)
А. Монгол улс Швейцари лугаа адил төвийг сахисан орны замаар хөгжинө
B. Хөрөнгөтөн баячуудыг төрүүлэх замаар улсаа хөгжүүлнэ
C. Нийгэм журамт ба эв хамт ёсны журмыг эрхэмлэнэ
D. Хувийн өмчид тулгуурласан хөрөнгөлөг нийгмийг бий болгоно
E. Франц улсын адил шилдэг сэхээтэнтэй улс болно
45. Монгол улсын түүхэнд “Хичээнгүй сайд” хэмээн алдаршин үлдсэн Ерөнхий сайд аль нь вэ? (1 оноо)
А. Д.Бодоо
B. С.Данзан
C. Ц.Дамдинбазар
D. Б.Цэрэндорж
E. А.Амар
46. 1929 - 1931 оны Зүүнтний нугалаа завхралд идэвхтэй оролцсон улс төрчид аль нь вэ? (2 оноо)
А. Д.Бодоо, С.Данзан, Д.Сүхбаатар
B. Б.Цэрэндорж, Ц.Жигжиджав,
C. Д.Лосол, Д.Чагдаржав, Д.Догсом
D. Л.Лааган, З.Шижээ, Ө.Бадрах
E. А.Амар, О.Жамьян, Ю.Цэдэнбал

47. Монголын томоохон сүм, хийд, лам нарын хөрөнгө хураах “Компани”-т ажлыг тухайн цагт хэрхэн нэрийдэж байсан бэ? (1 оноо)
 А. “Хүрээ хийдийн компани”
 В. “Лам нарын компани”
 С. “Их Шавийн компани”
 D. “Жасын компани”
 E. “Хутагт, хувилгаадын компани”
48. 1933 онд Оросын Дотоодыг хамгаалах газраас МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, хэн гэдэг хүнийг “Японы тагнуул” хэмээх зохиомол хэрэгт холбогдуулан хэлмэгдүүлсэн бэ? (1 оноо)
 А. Л.Лааган В. Г.Дэмид С. Ж.Лхүмбэ D. П.Гэндэн E. Ө.Бадрах
49. АНУ-ын дэд ерөнхийлэгч Дэвид Уэлес хэдэн оны хэдэн сард Монгол улсад айлчлал хийсэн бэ? (1 оноо)
 А. 1940 оны VI сард
 В. 1941 оны I сард
 С. 1944 оны VII сард D. 1945 оны X сард E. 1946 оны I сард
50. 1945 оны II сард ЗХУ, АНУ, Англи улсын төрийн тэргүүн нар уулзаж Гадаад Монголын статус кво (Оршин байгаа байдлыг) хүлээн зөвшөөрөх тухай ярилцсан бага хурал хаана болсон бэ? (2 оноо)
 А. Ираны Тегран
 В. Крымын Ялт
 С. Германы Подстам
 D. Польшийн Варшав E. Унгарын Будапешт
51. БНМАУ-ын улсын ардын аж ахуй, соёл боловсролыг хөгжүүлэх “Анхдугаар таван жилийн төлөвлөгөө” хэдий үеийг хамарч байсан бэ? (1 оноо)
 А. 1940-1944 он B. 1944-1948 он
 С. 1948-1952 он D. 1952-1956 он E. 1956-1960 он
52. 1960 онд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын чуулганаар 1940 оны үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан шинэ үндсэн хуулийг баталсан гэвэл энэхүү хуулийг баталсан АИХ-ын депутатууд хэд дэх удаагийн сонгуулиар сонгогдсон төлөөлөгчид байсан бэ? (2 оноо)
 А. 1 дэх удаагийн сонгуулийн
 В. 2 дахь удаагийн сонгуулийн
 С. 3 дахь удаагийн сонгуулийн
 D. 4 дэх удаагийн сонгуулийн
 E. 5 дахь удаагийн сонгуулийн
53. 1989 оны XII сарын 10-ны өдөр Монголын ардчилсан холбоо (МоАХ) байгуулагдсаныг албан ёсоор зарласан бөгөөд тэр үед МоАХ-ны удирдагч нь хэн байсан вэ? (1 оноо)
 А. Э.Бат-Үүл B. С.Зориг
 С. Ц.Элбэгдорж D. Р.Гончигдорж E. Д.Бямбасүрэн
54. 1990 оны VIII сарын 23-нд “Монголын нууц товчоо” зохиол бичигдсэний 750 жилийн ойг тэмдэглэн улмаар дурсгалын хөшөө босгосон байна. Хаана босгосон бэ? (1 оноо)
 А. Онон мөрний Дэлүүн болдог B. Гурван голын эх
 С. Хэрлэнгийн Хөдөө арал D. Ширээт цагаан нуур E. Хүрэн бэлчир
55. 1992 оноос Монгол улсын хууль тогтоомж Үндсэн хуулинд нийцэж байгаа эсэх талаар ямар байгууллага дүгнэлт гаргах болсон бэ? (1 оноо)
 А. Улсын прокурорын газар B. Үндсэн хуулийн цэц
 С. Улсын дээд шүүх D. Шүүхийн ерөнхий зөвлөл E. Ерөнхий прокурор

56. 1990 оноос хойш Монголын арилжааны банкууд дампуурч байсан хамгийн гол шалтгаан аль нь вэ? (1 оноо)
- A. Нэгэн зэрэг олон банк бий болсон
 - B. Зээлийг хяналтгүй, танил тал харан олгосноос
 - C. Гадаадын олон банкны салбар байгуулагдсан
 - D. Монгол мөнгөний ханш унасан
 - E. Үйлдвэрийн газрууд цөөн байсан

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

- a. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү**
b. Зөв хариулт бүр нэг оноотой.

- 2.1. Хүннү гүрний үед холбогдох дараах дурсгалуудыг олдсон газар нутагтай нь тохируулна уу? (5 оноо)
- | | |
|---|------------------------------------|
| 1. Хүннүгийн хэл хуур | a. Булган аймгийн Бүрэгхангай сум |
| 2. Хүннүгийн шаньюйн тамга | b. Төв аймгийн Батсүмбэр сум |
| 3. Бугын дүрс бүхий хээтэй эсгий ширдэг | c. Ховд аймгийн Үенч сум |
| 4. Ямаан усны хадны зураг | d. Төв аймгийн Алтанбулаг сум |
| 5. Луут буюу Лүнтэн хотын туурь | e. Өвөрхангай аймгийн Хархорин сум |
- 2.2. Дараах өгөгдлүүдийг харгалзуулна уу? (5 оноо)
- | | |
|-----------------------|---|
| 1. Хубилай Сэцэн хаан | a. Ухаант хаан хэмээн бичигдэн үлдэв |
| 2. Өлзийт Төмөр хаан | b. 1329-1332 оны хооронд хаан суужээ |
| 3. Хайсан Хүлэг хаан | c. Хубилай хааны дараа их ор суужээ |
| 4. Төгстөмөр хаан | d. Япон улсад 2 удаа цэрэг илгээв |
| 5. Тогоонтөмөр хаан | e. Булган хатан, Ананд ноён нарын хуйвалдааныг илрүүлэв |
- 2.3. XVII зуунд Монголын ноёд дотоод, гадаад асуудлаа хэлэлцэн шийдвэрлэх үүднээс хэд хэдэн удаа ноёдын чуулганыг хуралдуулсан бөгөөд тэдгээрийн он цагийг, чуулсан газар нутагтай нь тохируул. (5 оноо)
- | | |
|---------------------|------------------------------------|
| 1. 1640 оны чуулган | a. Заг Байдрагийн Хүрэн бэлчир |
| 2. 1686 оны чуулган | b. Өвөр Монголын нутаг Долоннуур |
| 3. 1689 оны чуулган | c. Ил Тарвагатайн Улаан бураа |
| 4. 1691 оны чуулган | d. Өвөр Монголын нутаг Ар элстэй |
| 5. 1636 оны чуулган | e. Өмнөд Монголын нутаг Мүгдэн хот |
- 2.4. Дараах түүхэн үйл явдал болсон он цагийг зөв харгалзуулна уу? (5 оноо)
- | | |
|--|------------|
| 1. Анхны иргэний сургууль байгуулагдав | a. 1919 он |
| 2. “Шинэ толь” сэтгүүл хэвлэгдэв | b. 1914 он |
| 3. Хиагтын 3 улсын гэрээ дуусав | c. 1912 он |
| 4. Монголын автономитийг устгав | d. 1913 он |
| 5. Улсын дээд, доод хурлыг байгуулав | e. 1915 он |